

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар: 16

Улаанбаатар хот

Нөхөн төлбөр олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 21 дүгээр зүйлийн 21.2.3, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 107/53 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.1.1, 4.1.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2023 оны эхний хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн Үндэсний статистикийн хорооноос гаргасан малын хорогдлын албан ёсны мэдээллийг үндэслэн “Малын индексжүүлсэн даатгалын гэрээ” болон “Малын индексжүүлсэн даатгалын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ”-нд заасны дагуу 13,930 даатгуулагчдад учирсан хохирол болох нийт 4,177,912,669.64 (дөрвөн тэрбум нэг зуун далан долоон сая есөн зуун арван хоёр мянга зургаан зуун жаран есөн төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн нөхөн төлбөрөөс 20,043,257.94 (хорин сая дөчин гурван мянга хоёр зуун тавин долоон төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн нөхөн төлбөрийг Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас, 2,240,109,806.25 (хоёр тэрбум хоёр зуун дөчин сая нэг зуун есөн мянга найман зуун зургаан төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн нөхөн төлбөрийг Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас тус тус гаргаж даатгагчдад олгосугай.

2. Дээд болон Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас нөхөн төлбөр авах даатгагчдын нэрс, давхар даатгагчаас даатгагчдад олгох нөхөн төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Олон улсын давхар даатгалын гэрээний дагуу Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас нөхөн төлбөрт олгосон 2,240,109,806.25 (хоёр тэрбум хоёр зуун дөчин сая нэг зуун есөн мянга найман зуун зургаан төгрөг хорин таван мөнгө) төгрөгөөс 1,810,752,808.03 (нэг тэрбум найман зуун арван сая долоон зуун тавин хоёр мянга найман зуун найман төгрөг гурван мөнгө) төгрөгийг олон улсын давхар даатгагч “СКОР” компаниас нэхэмжлэн авахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

4. 13,930 даатгуулагчийн нэрсийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах, Дээд болон Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас олгох нөхөн төлбөрийг Хамтын эрсдэлийн сангаас олгох 1,917,759,605.45 (нэг тэрбум есөн зуун арван долоон сая долоон зуун тавин есөн мянга зургаан зуун таван төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн нөхөн төлбөртэй нэгтгэн даатгагчдад хуваарилах, нөхөн төлбөр олгох ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулж, энэ талаарх тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ